



**НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 2/29

Улаанбаатар хот

Д.Отгонтуяаг түр орлон гүйцэтгэгчээр
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.4 Улсын Их Хурлын 2019 оны "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай" 21 дүгээр тогтоол, Засгийн газрын 2018 оны "Журам батлах тухай" 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам", Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 24 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/181 дүгээр захирамж, Хөдөлмөрийн дотоод журмын 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дамдинсүрэнгийн Отгонтуяаг 2019 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн жирэмсний болон амаржсаны амралттай байгаа Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн Хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээ хариуцсан мэргэжилтэн Нямсүрэнгийн Одонтуяаг ажилдаа орох хүртэлх хугацаанд түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Д.Отгонтуяагийн сарын үндсэн цалинг ТЗ-5-2 ангилал зэрэглэлээр 629,895 /зургаан зуун хорин есөн мянга найман зуун ерэн таван/ төгрөгөөр цалинжуулж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5 хувиар, зэрэг дэвийн нэмэгдлийг 15 хувиар тус тус тооцож, хууль тогтоомжид заасан бусад нэмэгдлийн хамт олгохыг нягтлан бодогч /Б.Батцоож/-д зөвшөөрсүгэй.

3. Д.Отгонтуяад ажил үүргийн хуваарь болон Хөдөлмөрийн дотоод журам, холбогдох хууль тогтоомжийг танилцуулж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс /Г.Ганзориг/-т даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлтийн хэлтэс /Г.Гантүшиг/-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.БАТХҮЛЭГ

1150500058